



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Булган аймгийн Бүрэгхангай сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн  
2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн  
тайлангийн аудит

Аудитын код: БУА-2020/2/СТА-ТТЗ

Цахим хуудас:  
[www.bulgan@audit.mn](http://www.bulgan@audit.mn)

Булган аймаг  
2020 он

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын  
тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр  
Утас:90900910 Цахим хаяг: Ankhbayard@audit.gov.mn  
Аудитын менежер: Ж.Энхцоодол  
Утас: 99057478 Цахим хаяг:Enhtsoodolj@audit.gov.mn  
Гэрээт аудитор: П.Эрдэнэзул  
Утас:99812414 Цахим хаяг: Erdenezulp@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

<b>Аудитын гэрчилгээ</b> .....	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил .....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	10
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	10
2.13. Шилэн дансны мэдээлэл .....	10
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	10
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
Менежментийн захидал.....	11
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан .....	13
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	13
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	14
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	18
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	21
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	22
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	<b>Error! Bookmark not defined.</b>



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,  
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2020.03.24 № 127

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_ т

БҮРЭГХАНГАЙ СУМЫН ЗАСАГ  
ДАРГА Н.ЭРХЭМБАЯР ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Бүрэгхангай сумын Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Бүрэгхангай сумын Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Бүрэгхангай сумын Засаг даргын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг, хариуцлага**

Бүрэгхангай сумын Засаг дарга нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн

006020208

тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

## Аудитын тайлан

### 2.1. Оршил

Бүрэгхангай сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Засаг дарга Н.Эрхэмбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн Бүрэгхангай сумын Засаг даргын нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бүрэгхангай сумын Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бүрэгхангай сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 11-нээс 2020 оны 03 дугаар сарын 14-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 16-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн Булган аймаг дахь Төрийн аудитын газрын гэрээт аудитор П.Эрдэнэзул хариуцаж хэрэгжүүлэв.

Бүрэгхангай сумын санхүүгийн нэгтгэсэн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын 2020 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 01/87 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас

санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

#### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бүрэгхангай сумын Засаг даргын үйл ажиллагааны эрхэм зорилго нь Төрийн үйлчилгээг иргэдэд тэгш, хүртээмжтэй хүргэх эвсэг, чадварлаг, мэргэшсэн хамт олныг бүрдүүлэн, орон нутгаа хөгжүүлэх нь бидний эрхэм зорилго оршино.

Бүрэгхангай сумын Засаг даргын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Орон нутгийн онцлогт тохирсон хөгжлийн бодлого боловсруулах
- Хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх
- Иргэдийн итгэлийг хүлээсэн манлайлагч нутгийн захиргааны байгууллага болох

#### **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Бүрэгхангай сумын Засаг даргын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Бүрэгхангай сум нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд CTS программ хангамж ашигладаг байна.

Бүрэгхангай сумын Засаг даргын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

#### **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Бүрэгхангай сумын Засаг даргын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 3 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

#### **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 3159039.5 мянган төгрөгөөс 2 тооцон 63180791.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 63180791.7 мянган төгрөгөөр тооцсон.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Бүрэгхангай сумын Засаг даргын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 24259.3 мянган төгрөгөөр буюу 0.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	359546.0	492403.8	-132857.7
Авлага	270202.2	214874.6	55327.5
Урьдчилгаа			
Бараа материал	185646.2	225018.7	-39372.4
Үндсэн хөрөнгө	5401239.	5260077.2	141161.8
<b>Нийт хөрөнгө</b>	<b>6216633.7</b>	<b>6192374.4</b>	<b>24259.2</b>
Өр төлбөр	4445.3	2690.4	1754.8
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	6212188.3	6189683990.13	22504.3
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>6216633.7</b>	<b>6192374.4</b>	<b>24259.2</b>

Авлага дансны үлдэгдэл буурсан нь сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлттэй холбоотой буурсан байна. Бусад авлагыг тодруулбал:

Байгууллагаас авах авлага

д/д	Байгууллага	Дүн	тайлбар
1	ОНХС	7.000.000	2015 онд үүссэн. Шүүхэд өгөөд хаяг тогтоох шүүхийн шийдвэр гарсан.
2	ЗДТГ	1.029.260	2014 онд үүссэн. Нэмэлтийн татан төвлөрүүлсэн хөрөнгийг авлагаар тусгаад хаагаагүй.
3	ЭМТ	10.000.000	2019 оны жилийн эцэст үүссэн. Тоног төхөөрөмж авах мөнгөө шилжүүлээд ондоо багтааж тоног төхөөрөмжөө авч амжаагүй авлага үүсгэсэн
	<b>ДҮН</b>	<b>18.029.260</b>	

Хувь хүмүүсээс авах авлага

Бүрэгхангай сумын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
санхүүгийн тайлангийн аудит

д/д	Байгууллага	Дүн	тайлбар
1	СХС	185.725.840	34 хүний СХС-ийн зээлийн авлага
2	ЖДҮДС	10.022.085	Баг хөгжүүлэх сангийн 2 хүний зээл 2030.000 төгрөг, Цэнгэл сангийн 8 хүний 7992085 төгрөгний зээл
3	ЗДТГ	1.097.444	1990 ээд онд үүссэн. Тодорхойгүй шүүхэд өгч шийдвэрлүүлнэ.
	<b>ДҮН</b>	<b>196.845.369</b>	

Байгууллагад төлөх өглөг

д/д	Байгууллага	Дүн	тайлбар
1	ОНЕ Орлого	1.000.000	2015 онд ерөнхий орлого руу СХС-ийн мөнгийг төлснийг авлагаар тусгасан.
2	ЗДТГ	1.437.400	2014 онд үүссэн. /Өвсний үнэ/ тодруулж барагдуулна
3	Цэцэрлэг	253.072	2019 онд үүссэн. Татварын өр
	<b>Дүн</b>	<b>2.690.472</b>	

Бараа материал оны эцэст 39372.4 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалт хийж бараа материалын нөөц үүсгэсэн нь ашиглалтгүй бараа материалын үлдэгдлийг нэмэгдүүлэх талтай ч дараа оны төсвийг хэмнэж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь акталсан болон шилжүүлсэн хөрөнгөнөөс шалтгаалжээ. Хөрөнгө оруулалтаар 83252.1 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй хүлээн авсан 56073.7 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь ЗДТГазарт 50000.0 мянган төгрөгөөр автомашин, 10000.0 мянган төгрөгөөр тоног төхөөрөмж, цэцэрлэгт 17648.0 мянган төгрөгөөр, ЕБС 3560.0 мянган төгрөгөөр тоног төхөөрөмж худалдан авснаас шалтгаалжээ. Үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлсэн 1433.2 мянган төгрөг, акталсан 18267.6 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Бусад 4459.2 мянган төгрөгийн өр нь он дамжсан эмийн өр үүссэн байна. Энэ нь орон нутгийн өмчит компанийн үйл ажиллагаатай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл буурсан нь 2018 онд газрыг бүртгэхдээ 95555.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж буруу бичсэнээс шалтгаалжээ.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга 95862.0 мянган төгрөгийн бичилт нь 2018 онд хөрөнгийн дахин үнэлгээ хийж газрыг биет бус хөрөнгөөр бүртгэхдээ 95555.0 мянган төгрөгөөр илүү бичсэн, мөн ерөнхий орлогын дансанд 1000.0 мянган төгрөгийн өглөгтэй байсныг 692.0 мянган төгрөг гэж алдаатай бүртгэсэнтэй холбоотой байна.

## 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Бүрэгхангай сум тайлант 2019 онд 124313.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 186513.7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 150 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Хүн амын орлого	48240	53638,1	-5398	111
Өмчийн татвар	4084,0	4087,0	-3	100
Бусад татвар	30279,0	38810,2	-8531,2	128
Татварын бус орлого	41710,0	89878,4	- 48168,4	216
<b>Нийт дүн</b>	124313.0	186513.7	62200.0	150

Сумын татварын орлого 62200.0 мянган төгрөгөөр давсан нь суманд үйл ажиллагаа явуулдаг уул уурхайн ААН-үүдэд татварын хяналт шалгалт хийж, татварын акт тавьж байгаль орчны зөрчил илрүүлсэнтэй холбоотой.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрт зориулан 2023465.7 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 12023465.7 мянган төгрөгийг урсгал зардалд, хөрөнгийн зардалд, 178681.8 мянган төгрөгийг зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 776739.8 мянган төгрөгийг улсын/орон нутгийн төсвөөс, 5439.4 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 125.9 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Хөрөнгө оруулалтын 9 төсөл, арга хэмжээнд 178681.8 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 78269.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2022622.5 мянган төгрөг буюу 99.9 хувь зарцуулсан байна.

**Нэмэлт төсөв:** Хандив тусламжаа 41127.1 мянган төгрөг, Засаг даргын нөөц хөрөнгөөс .170289.2 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 11760.1 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 615.4 мянган төгрөг, нийт 223791.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс нийт .223786.2 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 5.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

## **2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 3 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 0 эрсдэл тодорхойлж нийт 3 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар 62200.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

## **2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Бүрэгхангай сумын Засаг даргын санхүүгийн үйл ажиллагааг үр нөлөөтэй зохион байгуулах, дотоод хяналт, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна. Тухайлбал:

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг нийт дүнгээрээ 62200.0 мянган төгрөгөөр давж биелсэн, орлогыг нэр төрлөөр авч үзвэл үйл ажиллагааны орлого 10562.2, хөрөнгийн орлого 4037.1, шууд бус орлого 6541.9, улсын тэмдэгтийн хураамж 2732.2, хог хаягдлын үйлчилгээний хураамж 1274.3, ус рашааны нөөц ашигласны төлбөр 3579.2, торгуулийн орлого 23320.5 мянган төгрөгөөр тус тус давж биелсэн бол бусад орлого 322.0, тухай жилийн үйл ажиллагаанаас үл хамаарах бууны албан татвар 232.0 мянган төгрөгөөр тус тус тасалсан байна.

Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангаар нийт 58186.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсний 596.4 мянган төгрөгт төлбөрийн акт тогтоож, 46447.5 мянган төгрөгт албан шаардлага бичиж, зөрчлийг давтан гаргахгүй байх 11142.4 мянган төгрөгийн зөвлөмжийг тус тус хүргүүлсэн байна.

## **2.13. Шилэн дансны мэдээлэл**

Бүрэгхангай сумын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 154 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

## **2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж байхгүй байна.

## **2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Бүрэгхангай сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн -ны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Бүрэгхангай сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### *3.1 Орлогын данстай холбоотой асуудал*

#### **3.1.1 Илрүүлэлт:**

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг нийт дүнгээрээ 62200.0 мянган төгрөгөөр давж биелсэн, орлогыг нэр төрлөөр авч үзвэл үйл ажиллагааны орлого 10562.2, хөрөнгийн орлого 4037.1, шууд бус орлого 6541.9, улсын тэмдэгтийн хураамж 2732.2, хог хаягдлын үйлчилгээний хураамж 1274.3, ус рашааны нөөц ашигласны төлбөр 3579.2, торгуулийн орлого 23320.5 мянган төгрөгөөр тус тус давж биелсэн бол бусад орлого 322.0, тухай жилийн үйл ажиллагаанаас үл хамаарах бууны албан татвар 232.0 мянган төгрөгөөр тус тус тасалсан байна.

#### **3.1.2 Эрсдэл:**

Төлөвлөөгүй орлого орсноор зориулалт бус зардал гарах, төсвийн орлого тасарснаас эх үүсвэр дутагдах, хууль журам зөрчигдөх,

#### **3.1.3 Өгсөн зөвлөмж:**

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэх “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухай төсвийн байгууллагын өөрийн орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах, жил бүрийн орлогын биелэлтэд дүн шинжилгээ хийж орлогыг бүрэн төлөвлөх, тасарсан орлого биелэх боломж байгаа эсэх талаар судалгаа хийж байх.

### **3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Саналгүй.**

#### 3.2. Төсвийн шууд захирагчтай холбоотой асуудал

##### 3.2.1 Илрүүлэлт:

Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангаар нийт 58186.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсний 596.4 мянган төгрөгт төлбөрийн акт тогтоож, 46447.5 мянган төгрөгт албан шаардлага бичиж, зөрчлийг давтан гаргахгүй байх 11142.4 мянган төгрөгийн зөвлөмжийг тус тус хүргүүлсэн байна.

##### 3.2.2 Эрсдэл:

Хууль журам, зөрчигдөх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

##### 3.2.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн шууд захирагч, санхүү, бүртгэлийн ажилтны сахилга хариуцлагыг сайжруулах, дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах.

##### 3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Саналгүй

#### 3.3 Удирдлагатай холбоотой асуудал

##### 3.3.1 Илрүүлэлт:

Сумын Засаг дарга Боловсролын тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасан албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлэн Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4 дэх заалтыг зөрчин цэцэрлэгийн эрхлэгчид Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг дүгнэж үр дүнгийн урамшуулал олгох шийдвэр гаргасан нь тус хуулийн 30 дугаар зүйлд заасан аймгийн Засаг даргын бүрэн эрхийг хэрэгжүүлсэн байна.

##### Эрсдэл:

Хууль журам, зөрчигдөх.

##### 3.3.2 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4 дэх заалтыг зөрчин цэцэрлэгийн эрхлэгчид Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг дүгнэж үр дүнгийн урамшуулал олгох шийдвэр гаргах

##### 3.3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Саналгүй

Төсвийн захирагч зөвшөөрсөн дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар 20-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.АНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ж.ЭНХЦООДОЛ

БЭЛТГЭСЭН:

ГЭРЭЭТ АУДИТОР

П.ЭРДЭНЭЗУЛ

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>815.394.554,32</b>	<b>932.297.183,27</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	359.546.073,16	492.403.833,07
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	359.546.073,16	492.403.833,07
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	359.546.073,16	492.403.833,07
31211	Төрийн сангийн харилцах	359.546.073,16	492.403.833,07
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	270.202.210,19	214.874.629,00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	270.202.210,19	214.874.629,00
3351	Байгууллагаас авах авлага	114.351.089,19	18.029.260,00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	155.851.121,00	196.845.369,00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	185.646.270,97	225.018.721,20
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	24.756.056,67	20.067.657,00
35110	Тусгай зориулалттай материал	18.985.012,00	19.946.012,00
35130	Эм боох материал	5.771.044,67	121.645,00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	159.420.214,30	203.481.064,20
35410	Бичиг хэргийн материал	2.202.600,00	2.953.190,00
35420	Аж ахуйн материал	126.489.269,90	158.962.059,60
35430	Сэлбэг хэрэгсэл	3.842.500,00	3.950.000,00
35440	Түлш, шатах тослох материал	624.540,00	
35450	Барилгын засварын материал	271.200,00	605.619,00
35460	Хүнсний материал	24.849.804,40	35.048.195,60
35470	Бусад хангамжийн материал	1.140.300,00	1.962.000,00
35500	Биологийн хөрөнгө		
35600	Мал амьтад	1.470.000,00	1.470.000,00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>5.401.239.178,55</b>	<b>5.260.077.279,26</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	5.401.239.178,55	5.260.077.279,26
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	5.226.535.692,16	5.181.903.126,99
39201	Барилга, байгууламж, орон сууц	4.219.879.743,25	4.239.779.743,25
39202	Хуримтлагдсан элэгдэл	(163.107.253,92)	(342.864.278,71)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	262.515.747,00	295.737.969,00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(194.262.919,26)	(187.644.532,95)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	680.656.678,00	721.348.353,13
39206	Хуримтлагдсан элэгдэл	(183.722.583,92)	(213.573.618,56)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	168.885.764,13	223.421.013,66
39208	Хуримтлагдсан элэгдэл	(87.247.115,34)	(96.452.223,29)
39209	Зам, гүүрийн байгууламж	365.999.900,00	365.999.900,00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(22.966.625,18)	(42.516.612,74)
39214	Бусад үндсэн хөрөнгө	183.886.094,20	232.986.434,20
39215	Хуримтлагдсан элэгдэл	(26.922.669,60)	(39.486.502,80)
39217	Ном	22.940.932,80	25.167.482,80

Бүрэгхангай сумын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
санхүүгийн тайлангийн аудит

<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	174.703.486,39	78.174.152,27
39301	Програм хангамж	300.000,00	300.000,00
39303	Бусад биет бус хөрөнгө	174.403.486,39	78.848.486,39
39304	Хуримтлагдсан элэгдэл		(974.334,12)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>6.216.633.732,87</u></b>	<b><u>6.192.374.462,53</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>4.445.360,00</u></b>	<b><u>2.690.472,40</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	4.445.360,00	2.690.472,40
<b>413</b>	<b>Өглөг</b>	4.445.360,00	2.690.472,40
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1.300.000,00	-
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	3.145.360,00	2.690.472,40
41361	Байгууллагад төлөх өглөг	2.130.360,00	2.690.472,40
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	1.015.000,00	
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>6.212.188.372,87</u></b>	<b><u>6.189.683.990,13</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	6.212.188.372,87	6.189.683.990,13
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1.322.029.443,63	1.322.029.443,63
51101	Өмч: - төрийн	1.322.029.443,63	1.322.029.443,63
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	2.585.522.206,51	2.563.017.823,77
51210	Өмнөх үеийн үр дүн	1.428.470.146,05	2.489.660.166,51
51220	Тайлант үеийн үр дүн	1.157.052.060,46	73.357.657,26
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс		
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2.304.636.722,73	2.304.636.722,73
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>6.216.633.732,87</u></b>	<b><u>6.192.374.462,53</u></b>

#### 4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

##### САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3.638.432.929,35</b>	<b>3.232.397.245,47</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>88.838.105,00</b>	<b>96.535.665,73</b>
<b>110</b>	<b>Орлогын албан татвар</b>	48.596.772,54	53.638.264,70
<b>1100</b>	<b>Хувь хүний орлогын албан татвар</b>	48.596.772,54	53.638.264,70
110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх		
